

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/101/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК

Утас: 99862066 Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16_Тос95917377
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4.1 Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/101-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

БАРУУНБҮРЭН СУМЫН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
З. НАСАНЖАРГАЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,443,972.57	44,956,946.57
35	БАРАА МАТЕРИАЛ	33,443,972.57	44,956,946.57
35100	Түүхий эд материал	251,100.00	80,600.00
35130	Эм боох материал	251,100.00	80,600.00
35400	Хангамжийн материал	33,192,872.57	44,876,346.57
35410	Бичиг хэргийн материал	259,040.00	144,890.00
35420	Аж ахуйн материал	32,933,832.57	44,424,427.57
35460	Хүнсний материал	-	307,029.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	720,224,985.91	722,187,817.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	720,224,985.91	722,187,817.28
39200	Биет хөрөнгө	708,399,652.55	710,612,483.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	690,278,885.00	695,278,885.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(30,910,621.47)	(51,540,316.59)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	26,787,390.90	34,799,985.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,873,349.36)	(15,093,107.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,390,658.03	35,578,658.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,873,576.95)	(10,736,885.59)
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,550,003.60)	(3,825,005.40)
39217	Ном	1,184,801.00	1,184,801.00
39300	Биет бус хөрөнгө	11,825,333.36	11,575,333.40
39302	Хуримтлагдсан элэгдэл	(166,666.64)	(416,666.60)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,742,000.00	10,742,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	753,668,958.48	767,144,763.85
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	753,668,958.48	767,144,763.85
51	Засгийн газрын хувь оролцоо	753,668,958.48	767,144,763.85
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	79,821,603.00	79,821,603.00
51200	Хуримтлагдсан үр дүн	286,536,696.84	300,012,502.21
51210	Өмнөх үеийн үр дүн	105,843,935.52	286,536,696.84
51220	Тайлант үеийн үр дүн	180,692,761.32	13,475,805.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	387,310,658.64	387,310,658.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	753,668,958.48	767,144,763.85

2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	600,459,913.36	443,904,713.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	199,231,643.75	2,337,890.00
120	Нийтлэг татварын бус орлого	199,231,643.75	2,337,890.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	194,884,443.75	482,895.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,347,200.00	1,854,995.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,227,494.61	441,566,823.12
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	359,536,100.00	394,799,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	359,536,100.00	394,799,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	224,050.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	152,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	72,050.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,691,394.61	46,543,773.12
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,691,394.61	46,543,773.12
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	417,794,640.80	430,294,207.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,794,640.80	430,294,207.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,611,821.69	413,872,057.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,185,523.68	286,437,284.70
210101	Үндсэн цалин	200,069,235.09	207,265,734.16
210102	Нэмэгдэл	40,663,303.33	59,678,112.54
210104	Урамшуулал	19,452,985.26	19,493,438.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,371,238.21	38,305,575.07
210201	Тэтгэврийн даатгал	22,808,419.12	26,733,374.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,694,253.92	2,968,649.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,098,283.84	2,294,280.86
210204	Ажилгүйдлийн даатгал	524,569.03	573,570.07
210205	Эрүүл мэндийн даатгал	5,245,712.30	5,735,699.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,691,394.61	46,020,873.12
210301	Гэрэл, цахилгаан	2,793,955.39	3,504,554.94
210302	Түлш, халаалт	35,371,439.22	38,092,318.18
210303	Цэвэр, бохир ус	3,526,000.00	4,424,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,319,735.17	2,943,120.00
210401	Бичиг хэрэг	228,500.00	221,850.00
210402	Тээвэр, шатахуун	472,500.00	846,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	94,600.00	927,390.00
210404	Ном, хэвлэл	85,000.00	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	489,800.00	694,680.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	390,600.00	233,100.00
210408	Бараа материал акталсны зардал	5,558,735.17	-
2105	Нормативт зардал	13,626,564.00	10,722,141.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,500.00	120,800.00
210502	Хоол, хүнс	13,607,064.00	10,601,341.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	553,100.00	973,750.00
210604	Урсгал засвар	553,100.00	973,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	671,100.00	759,900.00

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	347,100.00	273,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	486,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,193,166.02	27,709,413.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	288,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,240,260.00	1,471,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,664,906.02	26,237,763.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,182,819.11	16,422,150.23
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,182,819.11	16,422,150.23
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,182,819.11	16,422,150.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	182,664,497.56	13,610,505.37
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,971,736.24	134,700.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,971,736.24	134,700.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	180,692,761.32	13,475,805.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	401,227,494.61	441,566,823.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,227,494.61	441,566,823.12
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	359,536,100.00	394,799,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	359,536,100.00	394,799,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	224,050.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	152,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	72,050.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,691,394.61	46,543,773.12
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,691,394.61	46,543,773.12
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	393,315,494.61	413,849,123.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,315,494.61	413,849,123.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,132,675.50	397,426,972.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,185,523.68	286,437,284.70
210101	Үндсэн цалин	200,069,235.09	207,265,734.16
210102	Нэмэгдэл	40,663,303.33	59,678,112.54
210104	Урамшуулал	19,452,985.26	19,493,438.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,371,238.21	38,305,575.07
210201	Тэтгэврийн даатгал	22,808,419.12	26,733,374.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,694,253.92	2,968,649.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,098,283.84	2,294,280.86
210204	Ажилгүйдлийн даатгал	524,569.03	573,570.07
210205	Эрүүл мэндийн даатгал	5,245,712.30	5,735,699.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,691,394.61	46,020,873.12
210301	Гэрэл, цахилгаан	2,793,955.39	3,504,554.94
210302	Түлш, халаалт	35,371,439.22	38,092,318.18
210303	Цэвэр, бохир ус	3,526,000.00	4,424,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,489,200.00	4,168,220.00
210401	Бичиг хэрэг	116,800.00	305,250.00
210402	Тээвэр, шатахуун	472,500.00	756,700.00

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	94,600.00	927,390.00
210404	Ном, хэвлэл	85,000.00	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,510,000.00	538,880.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,210,300.00	1,620,000.00
2105	Нормативт зардал	12,603,119.00	18,839,570.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	74,500.00	80,800.00
210502	Хоол, хүнс	11,744,919.00	10,908,370.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	783,700.00	7,850,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	567,100.00	1,186,450.00
210602	Тавилга	-	47,000.00
210604	Урсгал засвар	567,100.00	1,139,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	773,100.00	973,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	449,100.00	487,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	486,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,452,000.00	1,495,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	907,500.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,544,500.00	1,495,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,182,819.11	16,422,150.23
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,182,819.11	16,422,150.23
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,182,819.11	16,422,150.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,912,000.00	27,717,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,912,000.00	27,717,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,912,000.00	27,717,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,912,000.00	27,717,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,912,000.00	27,717,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(7,912,000.00)	(27,717,700.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	105,843,935.52	572,976,197.16
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	105,843,935.52	572,976,197.16
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	180,692,761.32	180,692,761.32
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	286,536,696.84	753,668,958.48
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	286,536,696.84	753,668,958.48
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	286,536,696.84	753,668,958.48
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	13,475,805.37	13,475,805.37
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	300,012,502.21	767,144,763.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	449,045,000.00	424,920,622.89	24,124,377.11	94.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	449,045,000.00	424,920,622.89	24,124,377.11	94.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,045,000.00	424,920,622.89	24,124,377.11	94.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,253,700.00	286,437,284.70	1,816,415.30	99.37
210101	Үндсэн цалин	210,655,500.00	207,265,734.16	3,389,765.84	98.39
210102	Нэмэгдэл	58,102,400.00	59,678,112.54	(1,575,712.54)	102.71
210104	Урамшуулал	19,495,800.00	19,493,438.00	2,362.00	99.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,612,700.00	38,305,575.07	1,307,124.93	96.70
210201	Тэтгэврийн даатгал	28,082,600.00	26,733,374.72	1,349,225.28	95.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,882,500.00	2,968,649.76	(86,149.76)	102.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,306,000.00	2,294,280.86	11,719.14	99.49
210204	Ажилгүйдлийн даатгал	576,500.00	573,570.07	2,929.93	99.49
210205	Эрүүл мэндийн даатгал	5,765,100.00	5,735,699.66	29,400.34	99.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,723,100.00	46,020,873.12	7,702,226.88	85.66
210301	Гэрэл, цахилгаан	7,671,000.00	3,504,554.94	4,166,445.06	45.69
210302	Түлш, халаалт	43,533,700.00	38,092,318.18	5,441,381.82	87.50

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	2,518,400.00	4,424,000.00	(1,905,600.00)	175.67
2104	Хангамж, бараа материалын зардал	3,978,800.00	3,944,170.00	34,630.00	99.13
210401	Бичиг хэрэг	126,800.00	233,200.00	(106,400.00)	183.91
210402	Тээвэр, шатахуун	487,500.00	756,700.00	(269,200.00)	155.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	981,700.00	927,390.00	54,310.00	94.47
210404	Ном, хэвлэл	92,200.00	20,000.00	72,200.00	21.69
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	562,400.00	386,880.00	175,520.00	68.79
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,728,200.00	1,620,000.00	108,200.00	93.74
2105	Нормативт зардал	31,487,900.00	18,839,570.00	12,648,330.00	59.83
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,800.00	80,800.00	-	100.00
210502	Хоол, хүнс	23,556,500.00	10,908,370.00	12,648,130.00	46.31
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,850,600.00	7,850,400.00	200.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,339,500.00	28,339,450.00	50.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,200,000.00	7,200,000.00	-	100.00
210602	Тавилга	15,000,000.00	15,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	6,139,500.00	6,139,450.00	50.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	129,600.00	-	129,600.00	-
210702	Дотоод албан томилолт	129,600.00	-	129,600.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,459,400.00	973,400.00	486,000.00	66.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	486,000.00	486,000.00	50.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,060,300.00	2,060,300.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,060,300.00	2,060,300.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	449,045,000.00	424,920,622.89	24,124,377.11	94.63
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	394,799,000.00	378,376,849.77	16,422,150.23	95.84
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	394,799,000.00	378,376,849.77	16,422,150.23	95.84
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС	54,246,000.00	46,543,773.12	7,702,226.88	85.80
320001	Орон нутгийн төсвөөс	54,246,000.00	46,543,773.12	7,702,226.88	85.80
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	208.00	52.00	156.00	25.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00	25.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	157.00	1.00	156.00	0.64
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	157.00	1.00	156.00	0.64
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	157.00	1.00	156.00	0.64
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	-	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч	25.00	25.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	224,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	224,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	224,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	224,050.00
210401	Бичиг хэрэг	0.00	72,050.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00
210406	Хог хаягдал, хортон шавьж	0.00	152,000.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	0.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	224,050.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	224,050.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	152,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	72,050.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид *Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг*/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Пийк-Ом Аудит ХХК-ийн аудитор А.Батболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь *“Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино”* гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тус цэцэрлэгийн үйл ажиллагааны гол чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны боловсрол олгох

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,

- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйл.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн .

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 417,794.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,177.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 2,924.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,857.1 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	33,444.00	44,957.00	11,513.00
Үндсэн хөрөнгө	720,225.00	722,187.80	1,962.80
Нийт хөрөнгө	753,669.00	767,144.80	13,475.80
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	753,669.00	767,144.80	13,475.80
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	753,669.00	767,144.80	13,475.80

Бараа материалын дансны үлдэгдэл 44,956.0 мянган төгрөг болж 11,513.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 24,703.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон хандиваар БСГ-аас 1,599.7 мянган төгрөгийн тоглоом, 181.7 мянган төгрөгийн маск, гар ариутгагч, санитол, бээлий, “Жайка олон улсын байгууллага”-аас 73.6 мянган төгрөгийн ариутгалын бодис зэрэг нийт 1,855.0 мянган төгрөгийн бараа материалыг тус тус үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 15,045.4 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 803,799.8 мянган төгрөг болж өмнөх оноос 28,200.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 27,717.7 мянган төгрөгийн эд хогшил, тавилга хэрэгсэл худалдан авч, БСГ-аас 428.8 мянган төгрөгийн угаалгын машин үнэ төлбөргүй авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 767,144.8 мянган төгрөг болж, 13,475.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 649,164.2 мянган төгрөг болж өмнөх оноос 156,554.4 мянган төгрөгөөр буюу 26.0 хувиар буурсан нь өмнөх оноос үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 430,294.2 мянган төгрөг болж өмнөх оноос 12,499.6 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар нэмэгдсэн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 26,251.7 мянган төгрөгөөр, тогтмол зардал 4,329.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардал 5,516.2 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 456,807.4 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 1,768.6 мянган төгрөгөөр бууруулж, 455,038.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр **449,045.0** мянган төгрөгийн төсөв баталснаас 394,799.0 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 54,246.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 394,799.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 46,543.8 мянган төгрөг, нийт 441,342.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **424,920.6** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 16,422.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 424,920.6 мянган төгрөг буюу 94.6 хувьтай тайлагнагдсан нь тогтмол зардал 7,702.2 мянга, норматив зардлыг 12,648.3 мянга нийт 20,350.5 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгалын санхүүжилтэд 152.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого болох 72.0 мянган төгрөгийн тендерийн орлого нийт 224.0 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. Боловсролын сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292, А/525 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу цахим болон танхимын сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроон, 3 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгт 449,045.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 424,920.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 5.4 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19,745.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. *Хууль тогтоомжтой холбоотой асуудал*

1.1 *Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:*

1.1.1 Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 9 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээлэл мэдээлээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.2, 6.3 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мэдээллийг хугацаанд мэдээлж байх

2. *Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал*

1.2 *Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд*

1.2.1 Илрүүлэлт: Тайлант онд 19,745.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг	2	19,745.0							2	19,745.0